



# СОЁМБОМЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.11. №72 (72)

Цахим шууданд

## САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ СУРГАЛТ БОЛОВ



Монгол цэргийн музейн 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах,

сэргээн засварлалтын чиглэлээр арга зүйн сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Монгол цэргийн музейд зохион байгуулж музейн албан хаагчид оролцлоо.

Сургалтад Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын Биет өв сэргээн засварлах газрын дарга М.Оюунтулга (Ph.D) “Музейн хадгалалт хамгаалалт”, “Музейн гэрэлтүүлэг ба

гэрэлтүүлгийн механизм” сэдвээр мөн Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын Биет өв сэргээн засварлах газрын сэргээн засварлагч, судлаач Э.Батжаргал “XRF буюу рентген багажид суурилсан материалын төрөл зүйлийн судалгааг элементийн түвшинд хийх арга ажиллагаа механизм” сэдвээр онол практик хосолсон сургалтыг тус тус явууллаа.

Тус сургалт нь музейн стандарт орчин, түүний хүрээлэн буй орчныг бүрдүүлэх олон талын харьцуулалт арга зүй, материал судлал, олон улсын стандартын харьцуулсан байдал, судалгааны арга зүйн талаар албан хаагчдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлсэн чухал ач холбогдолтой сургалт болж өндөрлөлөө.

Энэхүү үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын Биет өв сэргээн засварлах газрын дарга М.Оюунтулга (Ph.D), Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын Биет өв сэргээн засварлах газрын хамт олонд Монгол Цэргийн музейн удирдлага хамт олны зүгээс талархал илэрхийлэн цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүслээ.

## ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ БАЙЛДААНЫ ГАВЬЯАНЫ ОДОНТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 065 ДУГААР АНГИД

Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг өчигдөр Зэвсэгт хүчний 065 дугаар ангиар үргэлжилж байна.

Офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой түвшин тогтоох үзлэг нь 06 дугаар сарын 07-ний өдөр эхэлсэн юм.

Тус үзлэгт бэлтгэж Зэвсэгт хүчний 065 дугаар ангийнхон өнгөрсөн сарын 25-ны өдөр биеийн тамирын бэлтгэлжилтийн шалгалтаа өгсөн учир энэ удаад ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэжлийн түвшин, сахилга, ёс зүйн төлөвшил, эрүүл мэндийн байдал, сэтгэл зүйн байдал гэсэн дөрвөн үзлэгээр хангалттай гэсэн үнэлгээтэйгээр үргэлжиллээ.

Энэ удаагийн офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгээр ЗХЖШ-ын Захиргааны удирдлагын хэлтсийн Хуулийн тасгийн ахлах мэргэжилтэн, ахмад А.Эрдэнэманх сахилга, ёс зүйн төлөвшлийн тухайн алба хаагчийн сайшаал, шийтгэлийн

мэдээ, цагийн бүртгэл, гэмт хэрэг, зөрчил, дүрмийн бус харилцааны судалгаа, цолоо хугацаандаа авсан байдал зэргийг нь нарийвчлан үзэж, зохих оноог нь тавьж байв. Хэрэв сахилгын зөрчил гаргаж, ахлах даргын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, цолоо хугацаанаас өмнө авсан бол оноо хасах аж.

ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсийнхэн тухайн цэргийн алба хаагчийн сүүлийн 3 жил эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, донтолт, зан төрхийн эмгэгийг илрүүлэх асуумж авч, ажиллагааны удирдлагын газрын суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Т.Мөнхсаруул сэтгэл зүйн бэлтгэлжилтийн дүгнэлтийн хуудсыг хүн нэг бүрээр гаргаж байв. Залгуулаад ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр, Хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Л.Дагвасүрэн нар цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлагын талаар мэдээлэл нэгтгэж байхад ажлын хэсгийн зарим офицер хамт олны үнэлгээг гаргаж, бүрэлдэхүүнээс хуваарийн дагуу цэргийн мэргэжлийн шалгалтыг тестээр авав. Шалгалтыг техник, технологийн дэвшлийг ашиглан ID код буюу гар утсаар авч, хариуг нь тэр дор нь гарган, алба хаагчдад мэдээлж байлаа.



ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 6
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 19

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.	2.855.00
EUR 🇪🇺	3.438.00	3.498.00
CNY 🇨🇳	444.00	447.40
RUB 🇷🇺	38.50	40.20
JPY 🇯🇵	25.73	26.22
KRW 🇰🇷	2.48	2.61

### ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 28  
2021.06.11.  
/БААСАН ГАРАГ/

**ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН БАР ӨДӨР**

Үс засуулбал:  
**Нас ахар болно**  
Наран ургах, шингэх:  
**04.53-20.50**  
Барилдлага:  
**Идэр**  
Шүтэн барилдлага:  
**Мунхрахуй**  
Суудал:  
**Төмөр**

Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андагй тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, сэтгэлд сэтгэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсоод баруун урдагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

68.287

ЭДГЭРСЭН

55.157

НАС БАРСАН

324/6

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2819 (41)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

301

ЭДГЭРСЭН

2475

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 175,156,335

Эдгэрсэн

Нийт: 158,661,003

Нас барсан

Нийт: 3,776,236



ЦАХИМ ШУУДАНД

**АГААРЫН ЦЭРГИЙН НЭГДСЭН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ**



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал

2020-2021 оны Агаарын цэргийн командлалын "Цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний" дагуу Агаарын цэргийн анги салбарууд онлайн нэгдсэн команд штабын сургуульд оролцлоо. Энэ жилийн нэгдсэн команд штабын сургууль нь их онцлогтой болж өнгөрсөн юм. Тухайлбал, агаарын цэргийн анги, салбарууд бэлэн

байдлын дээд зэргүүдээ дахин шинэчлэн батлуулсантай холбогдуулж төлөвлөгдөн зохион байгуулагдав. Сургуулийн төгсгөлд ангиудыг байр эзлүүлснээр Зэвсэгт хүчний 065 дугаар анги гуравдугаар байранд шалгарсан амжилттай оролцсон юм.

Ахмад Ө.ЭНХСАРУУЛ

**САНСРЫН НИСГЭГЧ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
Ж.ГҮРРАГЧААГИЙН НЭРЭМЖИТ "ХУРДАЧ РАДИСТ-2021"  
ТЭМЦЭЭН АВАРГАА ШАЛГАРУУЛЛАА**



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүссэн байгуулагдсаны 100 жил, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойд зориулсан Оросын Холбооны Улс, Монгол Улсын баатар, сансрын нисгэгч, хошууч генерал Ж.Гуррагчаагийн нэрэмжит "Хурдач радиист-2021" тэмцээн Байлдааны гавьяаны одонт Зэвсэгт хүчний 065 дугаар ангид хоёр өдөр амжилттай явагдаж дууслаа.

Тэмцээний хүндэт зочдоор Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр, Сансрын хамтарсан нислэгийн 40 жилийн ойг тэмдэглэх Засгийн газрын комиссын гишүүн академич Б.Дэмбэрэл, ОХУ, Буриадын улсын гавьяат дасгалжуулагч, олон улсын хэмжээний мастер

"Өндөр хурд радио спорт" клубийн захирал, бэлтгэл хурандаа Н.Мижиддорж, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Б.Энхзоргол, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн захирагч, хурандаа Ш.Цэрэнбат нар оролцсон юм.

Тэмцээн гурван төрлөөр явагдсаны эрэгтэйчүүдийн төрөлд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тамирчин, сургагч ахлагч Ц.Болдбаатар, Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн тамирчин, ахлагч Х.Батчулуун, эмэгтэйчүүдийн төрөлд Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн тамирчин, ахлагч Н.Орologo, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн тамирчин, ахлах ахлагч Ш.Цэрэнлхам, Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн тамирчин,

ахлах дэслэгч С.Буянтогтох нар эхний байруудыг тус тус шалгарлаа.

Нийт багийн дүнгээр "Тэргүүн байр"-ыг Зэвсэгт хүчний 124 дүгээр анги, "Хоёрдугаар байр"-ыг Зэвсэгт хүчний 013 дугаар анги, "Гутгаар байр"-ыг Зэвсэгт хүчний 065 дугаар анги тус тус эзэлсэн амжилттайгаар тэмцээнийг дуусгасан юм.

Мөн энэ үеэр Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн радио спортын клубээс 6 тамирчинд I, II зэргийн үнэмлэх гардуулж, Зөвлөлт-Монголын Сансрын хамтарсан нислэгийн 40 жилийн ойн дурсгалын медалиар ахлах ахлагч Д.Амарсайхан, ахлагч Г.Лутбаяр нарыг шагнаж баг тамирчдад Ж.Гуррагчаа баатрын гарын бэлгийг гардууллаа.

**ДАРГЫН НЭРЭМЖИТ ШАЛГАЛТ ЭХЭЛЛЭЭ**



Өчигдөр чуулгын бие бүрэлдэхүүн ажлын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадвар, албаны хандлага, мэргэшлийн түвшин, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, үүрэг гүйцэтгэх чадвар, бэлэн байдал, хууль эрх зүйн мэдлэг, бие бялдрын болоод сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, шалгуур үзүүлэлтийг хангах даргын нэрэмжит шалгалтад хамрагдлаа.

Төрийн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжууд, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан Цэргийн дүрмүүд, ЗХЖШ-ын даргын "Цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах заавар", "Офицер ахлагчийн ёс зүйн дүрэм", "Цэргийн биеийн тамирын

бэлтгэлийн стандарт" зэрэг баримт бичгүүдийг мөрдлөг болгон ЦДБЭЧ-ын даргын тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн чуулгын бие бүрэлдэхүүнээс Удирдлагын баримт бичгийн үзлэг, жагсаалын үзлэг, цэргийн дүрэм, хууль эрх зүйн мэдлэг болон биеийн тамир, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-оор шалгалт авч, дүгнэсэн юм.

Төрийн далбаа, чуулгын тугаа хүндэтгэн залж, Төрийн дууллаа дуулж, жагсаалаар алхаж, чуулгын даргаас үүрэг чиглэл авсан алба хаагчид удирдамжийн дагуу шалгалт сорилдоо хамрагдаж эхэллээ.

**НОМЫН БАЯР ӨНӨӨДӨР ЭХЭЛНЭ**



Зургаадугаар сарын 11-13-нд УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор "Илүү их уншъя" уриатайгаар 29 дэх удаагийн номын баярыг Сүхбаатарын талбайд "Номын соёлт ертөнц ТББ"-аас 15 дахь жилдээ зохион байгуулах гэж байна.

Жил бүр номын баярт дунджаар 100 гаруй хэвлэн нийтлэгч компани, 80 орчим номын худалдаа эрхлэгч, 300-аад зохиолч, орчуулагч, редактор, зураач, эх зохиогч,

номын санч, 50000 гаруй уншигч оролцдог аж.

"Номын соёлт ертөнц" ТББ, "Ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж хамтран зохион байгуулагчаар Нийслэлийн засаг даргын тамгын газар ажиллах аж. Нээлтийн үйл ажиллагаа өнөөдөр 12 цагт төв талбайд болох бөгөөд бусад өдрүүдэд өглөөнөөс орой хүртэл үргэлжилнэ. Хавар, намрын тогтсон өдрүүдэд Сүхбаатарын

талбайд жил бүр зохиолч, хэвлэлийн компани, уншигчид хуран чуулж, гурван өдрийн турш мэдлэгийн их далайд уншигчдаа аялуулдаг. Жилээс жилд ач холбогдол, нийгмийн хүлээлт нь улам нэмэгдэж байна. Уламжлал ёсоор бол бид 2021.05.23-нд номын баярынхаа хаалтыг хийх байсан хэдий ч хөл хорионы дэглэм буураагүй энэ үед баярын товыг 2021.06.11-13 болж хойшуулжээ.